



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Г “Монголэмимпэкс” ХК-ийн үнэт цаасыг Г  
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголэмимпэкс” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 40,010,457 /дөчин сая арван мянга дөрвөн зуун тавин долоо/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000268